

ЭХ ОРОНЧ ҮНДЭСНИЙ ҮЗЭЛ БОЛ ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДСЭН АСУУДАЛ МӨН

Б.Лувсанравдан
Хилийн албаны сургуулийн дэд захирал,
доктор, хурандаа

Товч агуулга: Монгол Улсын хил нь монголчуудын олон зууны туршид хамгаалан хадгалж ирсэн үнэт зүйл бөгөөд хилийн аюулгүй байдал нь ард түмний, тэр дундаа хилчдийн эх оронч үндэсний үзэлд суурилж хангагдах зүй тогтол бүхий асуудал юм.

Түлхүүр үгс: Хилийн аюулгүй байдал, эх оронч үндэсний үзэл.

Эх орон гэх ойлголт улсын хилээсээ эхэлж, хил хязгаарынхаа аюулгүй байдлыг хангаснаар тусгаар тогтнол нь баталгааждаг зүй тогтолтой бөгөөд монголчууд түүхийн олон зуун жилийн туршид хил хязгаараа хамгаалан бататгахад эх оронч үндэсний үзэл чухал үүрэг гүйцэтгэсэн. Тийм ч учраас “Монгол эх орон хаанаас эхэлдэг вэ?” гэсэн асуултанд монгол хүн бүхэн “унасан газар, угаасан ус”, “дархан хил хязгаараас”-аас эхэлдэг гэж хариулдаг.

Бидний өвөг Модун хаан ширээнд суусны дараа түүнд Дорнод Ху нараас элч ирүүлэн Түмэн шаньюйд байсан мянган газрын гүйдэлтэй хүлэг морийг, дараа нь хайрт эхнэрийг авъя гэж хэлүүлэхэд Модун “Хөрш орноосоо агт морь, эм хүн харамлаад айлсан тогтнож болох гэж үү?” гээд тэр болгоныг Ху нарт өгчээ. Дорнод Ху нар улам бардамнан, өрнөд талдаа байгаа нутгийг эзэлж эхэлсэн бөгөөд “Танай, манай хоёрын хил болох оутогийн цаад талд эзэнгүй нутаг байна. Та нар түүнд хүршл/й, бид авъя” гэхэд Модун машид хилэгнэн Тазар бол улсын үндэс мөн, яахин өгч болно”¹ гээд уг газрыг харийханд өгөх санал гаргасан түшмэдүүдийн толгойг авч, дорно зүг цэрэглэн хөдөлж, дорнод Ху нарыг довтлон бут цохисон түүхтэй. Хүннү улсын үед газар нутаг, хил хязгаараа сэргийлэн хамгаалахад ихээхэн анхаарч давуу эрхтэй “Оуто” хэмээх хил хамгаалах тусгайлсан цэргийг зохион байгуулснаас үзэхэд монголчууд бид газар нутаг хил хязгаараа хамгаалснаар улсынхаа тусгаар тогтнол аюулгүй байдлыг баталгаажуулж ирсэн баялаг түүхтэй ард түмэн юм. Түүхч, судлаачид “Оуто” гэдэг үгийг “Хилийн харуул” гэж орчуулан тайлбарласан нь орчин үеийн хил хамгаалалтын анхны нэр томьёо ч тэр үед бий болсныг харуулж байна.

Эртний Хүннү гүрэн, Их Монгол улсын түүхээс гадна, ойрын 100 гаруй жилийн хугацаанд өрнөсөн гол үйл явдлууд болох 1911 оны үндэсний тусгаар тогтнолын хувьсгал, 1921 оны ардын ардчилсан хувьсгалын ололт, тусгаар тогтнол, 1939 оны халх голын байлдааны түүхэн ялалт, 1960-1980-аад оны социализмын их бүтээн байгуулалт, 1990-ээд оны ардчилсан хувьсгалын үр дүн, ардчилал, нийгэм эдийн засгийн шинэчлэл энэ бүхэн монгол хүн бүрийн эх оронч үндэсний үзлийн уламжлал шинэчлэл, залгамж чанарын бодит илэрхийлэл юм.

¹ Б.Балжинням. Дэлхийн монголчуудын түүх. II боть. 2015 он. 66 дахь тал

Монгол Улын хилийн түүхэнд “хилчид маань дайсантай тулалдахын зэрэгцээ өлсгөлөнтэй тэмцэж байв. Хоногийн манаанд гарсан хүн богийн 4 шийрний нормтой болж, цай давс тасарч, цэцэг, өвс хандлан ууж, хэвгээр гамбир хайрч, цас малтан турж үхсэн малын мах олж идэж өл залгах явдал бишгүй байжээ”² гэх мэт олон баримт байдаг нь хилчид хилийн аюулгүй байдлыг хангахдаа тохиолдсон бэрхшээл, хүндрэлийг өөрсдийн эх оронч үндэсний үзэл бүхий хариуцлага, эр зориг, тэвчээрийнхээ ачаар даван туулсан болохыг харуулдаг.

1980 онд МАХН-ын Төв хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга, маршал Ю.Цэдэнбал Баян-Өлгий аймаг дахь хилийн тусгай коментатурт байлдааны улаан туг гардуулах ажиллагаан дээр Монголын иргэн бүр “Хилчин” гэдэг үгийг “Эр зориг” гэдэг ойлголттой адилтган үздэг юм³ гэж хэлсэн нь хилчдийн алдрыг магтаж тэдний албаны мөн чанарыг тодорхойлсон төдийгүй хилчний албыг монголчууд хэрхэн хүндэтгэж бахархаж байсны илэрхийлэл юм.

Түүхэн эх сурвалжуудаас “эх орон” гэдэг бол улсын хил хязгаартай салшгүй холбоотой ойлголт бөгөөд газар нутгаа дээдлэх, хил хязгаараа хамгаалах нь төр, эр цэргүүдийн хамгийн чуал үүрэг хариуцлага болж ирсэн нь өнөөгийн хилчдийн эх оронч үндэсний үзлийн гол үндэс болсон гэж үзэх үндэстэй.

Хил хамгаалах байгууллагын улсын хил хамгаалалт, цэргийн сургалт бэлтгэл, бие бүрэлдэхүүнтэй зохиож буй сэтгэл зүй хангалтын ажил, ахуй хангалт, үйлчилгээ зэрэг нь залуучуудыг үндсэн хуулиар хүлээсэн цэргийн үүргээ ухамсартайгаар биелүүлэх, тохиолдох бэрхшээл саадыг даван туулж албаа нэр төртэй хаах, хамтач нөхөрсөг, ёс суртахуун, сахилга хариуцлагатай байх, эх орныхоо газар нутаг, хилийн аюулгүй байдлыг хамгаалахын үнэ цэнийг ухамсарласан эх оронч үндэсний үзлийн уламжлалтай. Өөрөөр хэлбэл Монгол Улсын хил нь хилчдийн төдийгүй нийт монголчуудын үндэсний үзлийн үнэт зүйл мөн юм.

Эх оронч үндэсний үзэл гэсэн дөрвөн үг нь нийлмэл хэлбэрээр нэг санааг илэрхийлж байгаа мэт боловч монгол хэлний тайлбар толийг үндэслэж задлан шинжилвэл бие даасан дараах ойлголтуудыг илэрхийлсэн нь харагдаж байна. Үүнд:

1. “Эх оронч” гэсэн утга нь “...төрсөн газар, орон нутаг, улс,... эх орноо хайрлах сэтгэл-эх орноо гэх бодол сэтгэлтэй хүн...”

2. “Үндэсний үзэл” нь “...Гарал угсаа, уг, овог үндэс...” болон “...ямар нэг юмны тухай хатуу баримталсан санал бодол...” гэсэн хоёр утгын нийлбэр тус тус хамаарч байна.

² ХХЕГ.Монгол улсын хил хамгаалалтын түүх.2008 он. 200 дахь тал

³ ХХЕГ.Хил хамгаалалтын түүх.2008 он. 175 дахь тал

Эртний сэтгэгчид, эрдэмтэн судлаачид эх оронч үндэсний үзлийн талаар судалгаа, шинжилгээний ажил хийж ирсэн бөгөөд тэдний судалгааны үр дүнгээс үзэхэд дараах дүгнэлт, тодорхойлолтууд анхаарал татаж байна.

1. Францын соён гэгээрүүлэгч Поль Анри Гольбах эх оронч үзлийг эрх чөлөөний хамгийн сайхан үр дагаварын нэг гэж үзэж эрх чөлөөгүй газар эх орон байх үндэсгүй.⁴

2. П.Гассенди эх орноо хайрлах үзэл нь ухаалаг байх, хүсэл зоргоо хязгаарлаж чаддаг байх, үхлээс айхгүй байх хүмүүжлээс бүрдэнэ.⁵

3. Их сэтгэгч Платон эх оронч үзэл нь эх орны эрх ашигт үйлчлэхэд чиглэгдсэн үйлсийг хэлэх бөгөөд энэ нь олон үеийн турш бүрэлдэн тогтсон гүн гүнзгий сэтгэлгээний нэг тод илрэл, эх оронч үзлийн үндсэн утга нь өөрийн эх орноороо бахархах, түүнийг хүндэтгэн хайрлах явдал юм.⁶

4. Оросын эрдэмтэн В.К.Левашов эх оронч үзэл гэдэг нь иргэдийн өөрийн эх орондоо хандах хандлагыг тодорхойлдог нийгэм ёс суртахууны зарчим юм.⁷⁸⁸

5. А.В.Вашенко өнөөгийн нөхцөлд хилийн аюулгүй байдлыг хангахад хил хамгаалах байгууллагын ажилтны эх оронч үзэл, ёс суртахуун их чухал нөлөөтэй зэрэг болно.

Харин Монголын эрдэмтэн, судлаачид эх оронч үндэсний үзлийн талаар өөрийн улсын уламжлал, хэрэгцээ, сэтгэлгээний онцлогт нийцүүлэн дараах байдлаар тодорхойлсон байна.

1. Эрдэмтэн зохиолч Л.Түдэв “Эх оронч үзэл” гэдэг нэр томьёо нь бодитой хийсвэр хоёр зүйлийн хослол үг юм. “Эх орон бол хэзээд бодитойгоор оршин байсаар, оршсоор байдаг, “үзэл” бол хийсвэр ойлголт учраас бодитой тусгал болж хоёрдогч чанараар сэтгэлд орших тул хийс ч болно, хадагдаж ч болно. “Эх орон” гэж бид бүхний өргөмжлөн ярьдаг тэр бодитой зүйл маань ердөө л “газар” гэсэн уугуул нэртэй билээ. Газар шороо байхгүйсэн бол хэн бүхэн орох орон, оочих усгүй тэгээд л оршин тогтнох аргагүй болно гэсэн үг”, “Эх орон” гэдэг маань газар шороо юм бол “эх оронч үзэл” хэмээх нь хүний сэтгэлд тээгдэн явдаг хийсвэр ойлголт юм.⁶

2. Судлаач Ц.Дашзэвэг эх оронч үзэл гэж нийгэм, төрийн амьдрал үйл ажиллагааны бүхий л хүрээн дэх хүний оюун санааны ололт бөгөөд эх орныхоо тусын төлөөх хүмүүсийн идэвхтэй үйл ажиллагаагаар тодорхойлогддог үнэт зүйлс мөн, эх оронч үзэл зөвхөн дайн тулааны үед бус, улс оронд учрах цаг зуурын аюултай нөхцөл байдал, тулгамдсан эдийн засгийн саад бэрхшээлүүдэд, тэдгээрийг даван туулахад, ерөөсөө л эх орноо хөгжүүлэхэд ард түмнийг

⁴ Поль Анри Гольбах. Избр. произв. в двух томах. 1. М. 1963. с. 42

⁵ Рогачев П. М. Свердловин М. А. Патриотизм-труд-творчество. с. 4

⁶ Человек и общество. Словарь справочник. "Финикс" Ростов На Дону. 1996 г. с. 260

⁷ Левашов. В. К. Патриотизм, в контексте современных социально-политических реалий. 2006 г. С. 67-76

⁸ Хил судлал. Сэтгүүл. 2003 он. 82 дахь тал

нягтруулж, уухайлах их хүч болдог ажээ. Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх нь Монгол Улсын язгуур эрх ашгийг бодлогын бүх түвшинд эн тэргүүнд тавих, монгол хүний хөгжил, эх оронч ухамсар, хандлага, монгол ахуй, өв соёл, зан заншлыг сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, чанарыг дээшлүүлэх суурь үндэс болно.⁹

3. Доктор Б.Бадарч “эх оронч үзлийг ёс суртахууны болон улс төрийн зарчим, нийгмийн мэдрэмжийг хэлнэ”.

4. Доктор, профессор Г.Дагважамц “эх оронч үзэл гэдэг бол эх орон, төрж өссөн өлгий нутаг, ард түмэн түүний түүх соёлд хязгааргүй хайртай байх, улс үндэснийхээ ашиг сонирхолд үнэнч, сайн сайхан бүхнийг эх болсон эх орныхоо төлөө зориулах эрмэлзлэл бүхий ертөнцийг үзэх үзэл юм”.¹⁰

5. Доктор Б.Солир “эх оронч үзлийг үндэсний эрх ашгийг дээдлэн хүндэтгэж, нийгмийн ба хувийн ашиг сонирхолыг зөв хослуулан үр бүтээлтэй ажиллаж, амьдарч, сурч байх нь монгол хүн бүрийн эрхэм шинж байвал зохимжтой”.¹¹

6. Хошууч генерал С.Гүржав “эх орон нь унаж төрсөн газар шороо, төрүүлж өсгөсөн аав ээж, түүх соёл, баялаг, үндэсний хэл, тогтоон бий болгосон хил хязгаарын нэгдэл, эх оронч үзэл гэдэг нь эх орон, ард түмэн, үндэсний соёл, бахархал, газар нутгаа хайрлах хувь хүний мэдрэмж, сэтгэлийн илэрхийлэл, ухамсар, үйл ажиллагааны нэгдэл юм”.¹²

7. Түүхийн ухааны доктор Д.Өлзийбаатар “нийгэм маань хэт аминч үзлийг, чадаж байгаа нь сайхан амьдрахыг хүмүүст тулгаж байна. Хаана амьдрах нь биш, яаж амьдрах нь чухал гэж их ярих боллоо. Үүний ард эх оронч үзлийн гал дөл унтрах аюул нүүрлэж байна. Монгол хүнд түүхийн их бахархал байдаг учраас эх оронч үзэл цусанд нь оршиж байдаг юм”.¹³

8. Доктор Б.Бор “...Ёс суртахууны хүмүүжлийн хамгийн чухал хэсэг бол эх оронч үзэл мөн. Эх орноо ойлгосон хайрласан хүн ажил, амьдралд өөдрөг байдаг, эх оронч үзэл шингэсэн хүн хувиа бодсон бэртэгчин зангүй байдаг гэх зэргээр тодорхойлсон байна.

Дэлхий улс, үндэстнүүдэд эх оронч үндэсний үзэл нь өөрийн түүх, соёл, онцлогоос хамааран уламжлагдан ирсэн бөгөөд эх орны төлөө амиа зориулах нь эх оронч үзлийн үндсэн шалгуур гэсэн цэрэг эх оронч уламжлалт ойлголтоос гадна нийгмийн ёс суртахуун, дэг журмыг сахин биелүүлэх, улс эх орны хөгжлийн төлөө хувь нэмрээ оруулах хариуцлагатай байх, түүх уламжлал, соёлоо дээдлэх гэсэн зарчим бүхий чиг хандлагад суурилах болсон байна. Бидний хөрш улсууд болон дэлхийн хөгжингүй зарим улс орнууд эх оронч үндэсний үзлийг улс эх

⁹ Н.Жалбажав нар. Эх оронч үзэл төлөвшил, уламжлал, шинэчлэл. 2008 он. 18 дахь тал

¹⁰ Г.Дагважамц. “Монгол Улсын хил хамгаалах албаны ёс суртахуун, сэтгэл зүйн хангалт” 2002 он

¹¹ Д.Дашзэвэг, Б.Солир. Монголчуудын эх оронч үзлийн түүхийн зангилаа асуудал. 1999 он. УБ. 9 дэх тал

¹² С.Гүржав. Хилчдийн сэтгэл зүйн бэлтгэлийг албанд харгалзан үзэх нь. УБ. 2004 он. 179 дэх тал

¹³ Д.Өлзийбаатар “Тусгаар тогтносон монгол улс бол өвөг дээдсийн урсгасан цус гаргасан ухаан дээр тогтсон чандмань эрдэнэ” Хилчин сэтгүүл. 2021 он. 46 дахь тал

орныхоо хөгжлийн түлхүүр болгон тодорхойлж иргэдээ бага балчираас нь түүх, уламжлал, соёлоо дээдэлдэг, үнэт зүйлсээрээ бахархдаг, ёс суртахуунаар төлөвшүүлж эх оронч иргэн төвтэй эдийн засгийн хөгжил бүхий нийгмийн тогтолцоог бий болгох хууль эрх зүйн орчин бүрдүүлхэд анхаарлаа хандуулан үр дүнд хүрч байгаа бөгөөд энэ нь манай улсын хувьд эх оронч үндэсний үзэл төлөвшүүлэхэд харгалзан үзэх туршлага болохоор байна.

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр баталсан “Монгол Улсын Үндсэн хууль”-д “...Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх...” гэсэн зорилт тодорхойлсон нь эх оронч үндэсний үзлийн суурь зарчмыг баталгаажуулсан гэж үзэх боломжтой бөгөөд “...Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж...”; “...хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн...”; “...хүний эрх, эрх чөлөө, шударга ёс...дээдлэх”; “...эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх...” гэсэн заалтууд нь эх орны эрх ашигт үйлчлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааны дэг журмыг хүндэтгэх хариуцлагын буюу эх оронч үзлийн, харин “...үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж...”; “...төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж...” гэсэн заалтууд нь үндэсний үзлийн буюу үндэсний соёл, түүх, урлагаар бахархах, хайрлан хамгаалах, тээн хөгжүүлэгч байх чиглэлд тус тус тодорхойлогдсон байна.

Монгол Улсын Их Хурлаас 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын “Эх оронч үндэсний үзлийг дээдлэх” гэсэн 1.2.1 дүгээр зүйлд “...Монгол Улсын иргэн бүрийн үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх эх оронч үндэсний үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно...” гэж заасан нь “Үндэсний аюулгүй байдал”-ыг хилийн аюулгүй байдлыг хангаснаар баталгаажуулах зүй тогтолтойг, мөн эх оронч үндэсний үзэл, хилийн аюулгүй байдлын харилцан хамаарлыг шууд тодорхойлсон бөгөөд “эх оронч үндэсний үзэл”-ийг дээдлэхийг Монгол Улсын иргэн бүрийн үйл ажиллагааны зарчим болгожээ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бодлогын баримт бичгийн нэг болох “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн 5.3 дахь заалтад “...Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүүхэд, залуучуудад цэрэг эх оронч үзэл, хүмүүжил олгох хичээлийн хөтөлбөрийг тусгаж, хэрэгжүүлнэ...”, Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого” нь “...Үндсэн хуулийн үзэл баримтлалд үндэслэсэн улсын хил, хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын талаархи Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндэс болсон залгамж чанартай тулгуур баримт бичиг мөн...”, “...2.1.3. улсын хил, хил

орчмын нутаг дэвсгэр дэх газар нутгийн уламжлалт монгол нэр, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хэвээр хадгалах", "...2.1.12. Иргэдийн эх оронч үзэл, улсын хил, хилийн дэглэм, журмыг хүндэтгэн сахих хүмүүжлийг төлөвшүүлэх", "....2.2.7. Хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх байгууллагуудыг эх оронч, мэдлэг, чадвартай боловсон хүчнээр хангах, тэдгээрийн нийгмийн хангамж, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулж, тэдний ар гэрийн нийгмийн баталгааг бодитоор дэмжих" гэх зэрэг заалтууд нь эх оронч үндэсний үзэл төлөвшүүлэхэд чиглэсэн ба Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь нийгмийн ёс суртахуун, сэтгэл зүйн төлөвшил, үнэт зүйлсийн нэгдмэл байдлыг хангаж эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархсан ард иргэд, байгууллагын үндэсний ашиг сонирхол бүхий эх оронч үндэсний үзэлд тулгуурлах нь тодорхой байна.

Хил хамгаалах байгууллагын бие бүрэлдэхүүнтэй зохион явуулж буй "Сэтгэл зүйн хангалтын ажил"-ын зорилго, зорилт, чиг үүргийг эх оронч үндэсний үзлийн онолын үндэс, эрх зүйн зохицуулалт, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тодорхойлж "Сэтгэл зүйн хангалтын ажил"-ын төрлүүдэд нарийвчлан зааж хэрэгжүүлэх нь зүйтэй.

Дүгнэлт

Эх оронч үндэсний үзлийг монгол хэлний тайлбар толь, эрдэмтэн судлаачдын дүгнэлтүүдэд үндэслэн "Улс эх орны эрх ашигт үйлчлэхэд чиглэгдсэн дэг журмыг хүндэтгэн сахих, эх орны эрх ашиг, үндэсний үнэт зүйлсийг ямагт эрхэмлэн дээдлэх ёс суртахууны мэдрэмж юм" гэж тодорхойлж болохоор байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн эрхэм зорилго, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын "Эх оронч үндэсний үзлийг дээдлэх" гэсэн заалтын агуулга нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах, эх оронч үндэсний үзлийг төлөвшүүлэх төрийн бодлогын үндэс, нийгмийн бүхий л салбарын үйл ажиллагааны эрх зүйн хэм хэмжээ, үзэл санаа, нийт ард түмний амьдрал, үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, эх оронч үндэсний үзэл төлөвшүүлэх нийгмийн харилцааг зохицуулах бусад хууль тогтоомжуудад чиглэл бүхий эрх зүйн үндсэн эх сурвалж болсон бөгөөд Монгол Улсын "Гадаад бодлогын үзэл баримтлал", "Батлан хамгаалах бодлогын үндэс", "Төрөөс хилийн талаар баримтлах бодлого", "Алсын хараа-2050" хөгжлийн хөтөлбөр, "Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр" зэрэг бодлогын бичиг баримтууд нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, түүн дотроо хилийн аюулгүй байдал ба эх оронч үндэсний үзлийн хамаарал, ач холбогдлыг чиглэл бүртээ нарийвчилж эх оронч үндэсний үзэл нь үндэсний аюулгүй байдлын үндэс болохыг бататгасан байна.

Өнөөдөр цэргийн албанд татагдаж ирж буй залуучуудын сэтгэл зүйн бэлтгэл, ёс суртахууны төлөвшил хангалтгүй, цэргийн болон хил хамгаалах албаны үүрэг, ач холбогдол, үнэт зүйлсийн талаар мэдлэг, мэдээлэл хомс, хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг сөрөг мэдээлэлд дүгнэлт хийж хүлээн авдаг болсон нь судалгааны дүнгээс харагдаж байна. Иймд хил хамгаалах байгууллагаас нийгэмд Монгол Улсын хил нь эх оронч үндэсний үзлийн баталгаа болох, хил хамгаалах байгууллага, хилчдийн баатарлаг алдар гавьяаны тухай

сургалт, сурталчилгааг идэвхтэй зохион байгуулж тэднийг улсын, хилээр бахархах, уг албыг хаах хүсэл тэмүүлэл төрүүлэхэд анхаарал хандуулж Монгол Улсын хил бол “Үндэсний үнэт зүйл” мөн болохыг сурталчлах замаар эх оронч үндэсний үзлийг онолын үндэслэл, эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн төлөвшүүлэх нь зүйтэй.

Санал

-Дотоод хэргийн их сургууль, Хил хамгаалах ерөнхий газар тус тус “Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангах;

-Хил хамгаалах байгууллага “Алсын хараа-2050” хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1.4.1-т заасан “Улс, үндэстний эх орон, газар нутаг, тусгаар тогтнолоороо бахархах үзлийг сэргээж, Монголчуудын уламжлалт төрт ёсны үзэл, сургаалыг орчин үед нийцүүлэн хөгжүүлж эх оронч үзэл, үндэсний эв нэгдлийг төлөвшүүлнэ”, “Хүүхэд залуучуудад эх оронч үндэсний үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.5-д заасан “Өмчийн хэлбэр харгалзахгүй бүх шатны байгууллага, аж ахуйн нэгжид хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үйл ажиллагааг уялдуулах, хамтран хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх” гэсэн заалтын дагуу нийслэлийн боловсролын газар болон дүүргүүдийн цэргийн штабуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулж хүүхэд, залууст эх оронч үндэсний үзэл төлөвшүүлэх чиглэлд хамтран ажиллах, 4.2.2-т заасан “Эх оронч үзэл төлөвшүүлэх, аюулгүй амьдрах арга ухаан олгох, бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагаанд ашиглах хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичиг, сургалтын материал, хэрэглэгдэхүүн, гарын авлагыг боловсруулахдаа монгол хүний өвөрмөц онцлог, улс орны хөгжилд хувь хүн бүрийн оролцоо чухал гэдгийг ойлгуулж, эх орноороо бахархах агуулгыг тусгах” гэсэн чиглэлийн дагуу дунд сургуулийн суурь боловсролын сургалтын хөтөлбөрт Монгол Улсын хил нь эх оронч үндэсний үзлийн илэрхийлэл болж ирсэн түүхэн агуулгыг тусгах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх зэрэг ажлуудыг зохион байгуулах нь нийгэмд эх оронч үндэсний үзэл төлөвшүүлэх чухал ажил болох бөгөөд ирээдүйн хилчдийг эх оронч үндэсний үзлээр төлөвшүүлж албанд бэлтгэх;

-ДХИС-ийн хувьд сонсогч, суралцагчдад эх оронч үндэсний үзэл төлөвшүүлэх, төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдын хариуцлага, шударга ёсны зарчим бүхий эх оронч үндэсний үзлийн талаарх сургалт, эрдэм шинжилгээ, соёл олон нийтийн ажлын чиглэлд анхаарал хандуулах нь нийгмийн хэрэгцээ, шаардлага болж байгаа тул уг ажлыг Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн хөтөлбөр, Засгийн Газрын 200 дугаар тогтоол буюу “Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-т нийцүүлэн зохион байгуулах нь зүйтэй.

Эх сурвалжийн жагсаалт

- ХХЕГ. Монгол улсын хил хамгаалалтын түүх. 2008 он
- Б.Балжинням. Дэлхийн монголчуудын түүх.II боть
- "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн хөтөлбөр
- "Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"
- Поль Анри Гольбах. Избр.произв.в двух томах.1 .М. 1963
- Рогачев П.М.Свердлин М.А.Патриотизм-труд-творчеств.
- Человек и общество. Словарь справочник. "Финикс" Ростов На Дону.1996

Г.

- Левашов.В.К. Патриотизм, в контексте современных социально-политическихреалий. 2006 г.

- Хил судлал.Сэтгүүл. 2003 он.

- Н.Жалбажав нар. Эх оронч үзэл төлөвшил, уламжлал, шинэчлэл. 2008 он

- Г.Дагважамц. "МУ-ын хил хамгаалах албаны ёс суртахуун.сэтгэл зүйн хангалт".2002 он

- Д.Дашзэвэг, Б.Солир. Монголчуудын эх оронч үзлийн түүхийн зангилаа асуудал. 1999 он

- С.Гүржав. Хилчдийн сэтгэл зүйн бэлтгэлийг албанд харгалзан үзэх нь.

УБ. 2004 он.

- Д.Өлзийбаатар "Тусгаар тогтносон монгол улс бол өвөг дээдсийн урсгасан цус.гаргасан ухаан дээр тогтсон чандмань эрдэнэ" Хилчин сэтгүүл. 2021 он.